

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Эрдэнэт медиал эмнэлэг ХХК-ийн
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/05/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Эрдэнэт хот

2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.26 № 95

танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ МЕДИКАЛ ЭМНЭЛЭГ
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.СУВДАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Эрдэнэт медикал эмнэлэг ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Эрдэнэт медикал эмнэлэг ХХК -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 255.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажаагүй 27 байгууллага, иргэний 74.6 сая төгрөгийн өр төлбөр, 14 байгууллагын 166.3 сая төгрөгийн авлага авлагыг санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан.
- Агуулахад шилжүүлсэн, ашиглахгүй байгаа 151 нэр төрлийн 354.7 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийн элэгдлийг зогсоосон зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл

хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/778 дугаар тушаалаар тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, тайлант онд 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдэд 7.9 сая төгрөгийн урамшуулал, 1.2 сая төгрөгийн хоолны зардал зарцуулсан байна.

Хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халсан нь шүүхээр тогтоогдсон 2 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 131.3 сая төгрөг олгож, шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Компанийн бизнес төлөвлөгөөний зорилтот түвшинд төлөвлөсөн орлого, зардал 25 хувиар, татварын өмнөх болон дараах ашиг 35 хувиар тус тус буурсанд оновчгүй төлөвлөлт болон эдийн засгийн тооцоо судалгаа үр нөлөөгүй, хяналт хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүй байхад эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 31,474.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэж, 19,341.6 сая төгрөгөөр үнэлж, үнэ цэн 12,132.9 сая төгрөгөөр буурсан байна.

Эрдэнэт медиал эмнэлэг ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны онцлогт тохирсон журам, заавар боловсруулаагүй байна.

Эрдэнэт медиал эмнэлэг ХХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөөний зорилтот түвшинд нийт орлогыг 20,278.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 20,250.2 сая төгрөгөөр тооцоолж, 25.6 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,361.2 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15,215.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,197.4 сая төгрөгийн зардал гарган, 16.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 138 дугаар тогтоолоор төрийн өмчит төрөлжсөн эмнэлэг байгуулж, эмнэлгийн дүрэм батлах, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг Эрүүл мэндийн сайд, санхүүжилтийг шийдвэрлэхийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т, эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хариуцуулсныг улсын бүртгэлд бүртгэхдээ хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж бүртгэсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,665,102,522.70	7,607,029,857.90
1.1.2	Дансны авлага	943,871,716.15	1,325,799,255.07
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,391,970.97	11,644,580.27
1.1.6	Бараа материал	1,538,943,369.58	1,924,499,588.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо	467,857,143.37	48,267,776.40
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,618,166,722.77	10,917,241,057.80
1.2.	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	40,870,220,793.29	26,754,541,273.64
1.2.2	Биет бус хөрөнгө	4,415,961,527.33	3,856,391,942.40
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	45,286,182,320.62	30,610,933,216.04
1.3.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	53,904,349,043.39	41,528,174,273.84
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1.	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	186,138,420.98	241,607,295.28
2.1.1.2	Цалингийн өглөг	160,696,512.00	210,725,344.00
2.1.1.3	Татварын өр	210,535.00	111,406,002.11
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	347,045,467.98	563,738,641.39
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	7,137,800,000.00	6,661,131,944.45
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,429,189,115.98	2,429,189,115.98
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,566,989,115.98	9,090,321,060.43
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,914,034,583.96	9,654,059,701.82
2.3.	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч : а. Төрийн	46,769,685,718.46	46,769,685,718.46
2.3.9	Хуримтлагдсан ашиг / алдагдал /	(2,779,371,259.03)	(14,895,571,146.44)
2.3.10	Тайлангийн үеийн	(2,800,595,589.63)	16,707,760.31
2.3.11	Өмнөх үеийн	21,224,330.60	(14,912,278,906.75)
2.3	Эзэмшигчдийн өмчийн дүн	43,990,314,459.43	31,874,114,572.02
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	53,904,349,043.39	41,528,174,273.84

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	10,486,942,564.74	14,787,871,638.25
2	Борлуулалтын өртөг	9,571,099,440.34	11,094,048,237.85
3	Нийт ашиг / алдагдал /	915,843,124.40	3,693,823,400.40
4	Түрээсийн орлого	26,726,400	8,078,400

5	Хүүгийн орлого	225,332,497.47	399,637,779.48
8	Бусад орлого	7,746,854.94	20,339,790.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	166,832,485.78	140,611,534.63
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,785,677,926.75	3,921,202,525.46
11	Бусад зардал	23,814,300.00	41,512,515.60
12	Гадаад валютын ханшийн зөрүүний олз / гарз /	80,246.09	11,383.93
13	Татвар төлөхийн өмнөх ашиг / алдагдал /	(2,800,595,589.63)	18,564,178.12
14	Орлогын татварын зардал		1,856,417.81
15	Татварын дараах ашиг / алдагдал /	(2,800,595,589.63)	16,707,760.31
16	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-
17	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(2,800,595,589.63)	16,707,760.31
18	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
19	Орлогын нийт дүн	10,746,748,317	15,215,927,608

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	46,769,685,718.46	(2,779,371,259.0)	43,990,314,459.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Залруулсан үлдэгдэл	46,769,685,718	(2,779,371,259)	43,990,314,459
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		16,707,760.31	16,707,760
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт		(12,132,907,647.72)	(12,132,907,648)
Зарласан ногдол ашиг	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	46,769,685,718.46	(14,895,571,146.44)	31,874,114,572.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн +/-	17,337,088,553.97	14,529,349,276.74
1.1.1.	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	9,949,471,748.80	14,500,931,086.74
1.1.2.	Татаас, санхүүжилтийн орлого	7,137,800,000.00	
1.1.3.	Бусад мөнгөн орлого	249,816,805.17	28,418,190.00
1.2.	Мөнгөн зарлагын дүн - / - /	15,952,995,276.45	10,023,706,576.52
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	3,181,913,958.00	3,852,565,174.00
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	913,000,000.00	1,152,405,829.00
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	9,957,399,883.28	2,757,378,271.65
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	308,695,097.23	341,739,265.46
1.2.5.	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	123,462,965.00	19,062,600.00
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	529,268,337.58	426,980,565.26

1.2.8.	Даатгалын төлбөрт төлсөн	1,732,240.00	4,036,000.00
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	937,522,795.36	1,469,538,871.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,384,093,277.52	4,505,642,700.22
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн /+/-	225,332,497.47	359,674,001.53
2.2.1.	Хүлээн авсан хүүгийн орлого	225,332,497.47	359,674,001.53
2.2	Мөнгөн зарлагын дүн /-/-	-	2,446,721,311.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,999,091,252.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		447,630,059.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	225,332,497.47	(2,087,047,309.47)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн /+/-	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн /-/-	-	476,668,055.55
3.2.1.	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		476,668,055.55
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(476,668,055.55)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,609,425,774.99	1,941,927,335.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,055,676,747.71	5,665,102,522.70
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,665,102,522.70	7,607,029,857.90

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	Баталсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/	Хувь
1	Нийт орлого	сая.төг	20,278.70	15,215.90	(5,062.80)	75.0
2	Нийт зардал	сая.төг	20,250.20	15,197.40	(5,052.80)	75.0
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	28.50	18.50	(10.00)	64.9
4	Орлогын албан татварын зардал	сая.төг	2.90	1.85	(1.05)	63.8
5	Татварын дараах ашиг, алдагдал	сая.төг	25.60	16.70	(8.90)	65.2
6	Борлуулалтын 1 төгрөгт оногдох зардал	сая.төг	0.99	1.00	0.01	101.0
7	Нийт ажилтны тоо	хүн	167	162	(5.00)	97.0
8	Нийт цалингийн сан	сая.төг	5,155.10	5,007.70	(147.40)	97.1
9	Хөрөнгө оруулалт	сая.төг	2,361.20	1,300.00	(1,061.20)	55.1

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 255.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 6.0 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 249.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 6 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Төсвөөс 2.8 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан, бэлэн мөнгөний кассаас анхан шатны баримтгүй 1.0 сая төгрөг зарцуулсан, бэлэн мөнгөний кассыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөр тоолж шалгахад 1.0 сая төгрөг дутсан, 12 сард байгуулагдсан Төлөөлөн удирдах зөвлөлд 1.2 сая төгрөгийн хоолны зардал олгосон зөрчлүүдэд 4 төлбөрийн акт тогтоов.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

Худалдан авсан 8.8 сая төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгээгүй, хүлээн авсан актгүй, санхүүжилт олгосон, агуулахад шилжүүлсэн, ашиглахгүй байгаа 354.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг зогсоосон бөгөөд элэгдэл тооцохгүй байх шийдвэр гаргаагүй, тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй 27 байгууллага, иргэний өр төлбөр бүртгэж тайлагнасан, тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй 14 байгууллага, иргэний өр төлбөр бүртгэж тайлагнасан, тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 талбарын мэдээллээс 10 талбарын мэдээллийн хугацааг хоцроож, 27 талбарын мэдээллийг огт мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 18 мөнгөн гүйлгээний 923.2 сая төгрөгийн мэдээлэл ил тод байршуулаагүй зөрчлүүдэд 5 албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулахаар 2024 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл ихтэй, эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалтын хугацааг тодорхойлох зорилгоор түүвэрлэн, 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн 6037 ширхэг 59,237,463.19 төгрөгийн бараа материал, эм хангамжийн материалд бүртгэлтэй 25 нэр төрлийн 85,281 ширхэг 388,117,682.02 төгрөгийн өртөг бүхий бараа материалд тооллого хийсэн.

Тооллого хийсэн өдрөөрх үлдэгдэлд зарлагын гүйлгээг тухай бүр хийдэггүй, 7 хоногтоо 1 удаа хийдэг учраас бараа материалын үлдэгдэлтэй таарахгүй байсан тул зарлагыг бүрэн гүйцэд шивж тооллогыг ахин гүйцэтгэхээр болоход тохируулсан байна. Бараа материалын орлого, зарлагын гүйлгээг тухай бүр программд гүйцэтгэх, гэнэтийн тооллого хийх, дотоод хяналтыг үр нөлөөтэй байлгахад анхаарч ажиллах шаардлага үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 1:

Бараа, материалын агуулахын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, анхан шатны бүртгэл хөтлөлтөд анхаарч, хяналт хэрэгжүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2:

Компанийн бэлэн мөнгө хадгалах сейф нь бараа материалын агуулахад байдаг бөгөөд хяналтын камергүй, мөнгөн хөрөнгийн нярав тухай бүр хянах боломжгүй, ус чийг нэвтрэхээр

эрсдэлтэй бүсэд байршиж байна. Кассад хэрэгцээнээс илүү мөнгө хадгалах явдлаас зайлсхийх үүднээс жижиг мөнгөн сангийн хэмжээг нарийвчлан тогтоогоогүй, кассын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж 2:

Компанийн мөнгөн кассын ажиллагааны журмыг баталж, мөрдөн ажиллах.

Илрүүлэлт 3:

Байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон журам, заавар боловсруулаагүй, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 3:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөж ажиллах.

3. Бизнес төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 4:

Бизнес төлөвлөгөөнд баталсан орлогын төлөвлөгөө 5,062.8 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар тасарсан ба зорилтот түвшний биелэлтийг тайлагнаагүй, дүн шинжилгээ хийгээгүй байна. Энэ нь Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", "Эрдэнэт медиал эмнэлгийн дүрэм"-ийн 3.5-ын 2 дах хэсгийн 2.5-д "санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлах, гүйцэтгэл, үр дүнд суурилсан эдийн засгийн үр ашиг, оновчтой бодлогыг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 4:

Байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн тооцоо, судалгааг үндэслэн бодитой төлөвлөн, батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Илрүүлэлт 5:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 55 хувийн гүйцэтгэлтэй ба худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний дотор дуусгах арга хэмжээ хэрэгжүүлээгүй, 1 арга хэмжээг он дамжин хэрэгжих гэж дараа оны бизнес төлөвлөгөөнд батлуулахаар хэлэлцүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.2-т "энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд

худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 5:

Худалдан авах ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр нөлөөг сайжруулах.

4. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт 6:

Байгууллагын архивын үйл ажиллагаа хангалтгүй, хадгаламжийн нэгж үүсгэсэн санхүүгийн баримт материалуудыг агуулахад хадгалж байна. Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.4.3-т "баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах,"; 46.2-т "Байгууллагын зохион байгуулалтын нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтан албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах бөгөөд тэдгээрт байгууллагын удирдлага хяналт тавина." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 6:

Байгууллагын архивын хадгалалт, хамгаалалтад анхаарч, холбогдох хууль, журмыг мөрдөж, дотоод хяналтыг сайжруулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт медиал эмнэлэг ХХК												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт медиал эмнэлэг ХХК	8	252.9	3	3.2	4	249.7	1	-				
Дүн	8	252.9	3	3.2	4	249.7	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										

Эрдэнэт медиал эмнэлэг ХХК	1				1			
Дүн	1							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эрдэнэт медиал эмнэлэг ХХК	6	2.8	1	2.8			5	
Дүн	6	2.8	1	2.8			5	
Нийт дүн	7	2.8	1	2.8	1		5	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨА	1	1			1			
	НИЙТ	1	1			1			